

ЖОЙС МАЙЕР

АМАР ТАЙВАН

Бүх Санаа Зовнилоо Түүнд Үүрүүл

АМАР ТАЙВАН

Бүх санаа зовнилоо Түүнд үүрүүл

ЖОЙС МАЙЕР

Улаанбаатар
2015

Номонд ашиглагдсан бүх Библийн эшлэлүүдийг
Ариун Бичээс Библийн Нийгэмлэгийн 2004 оны “Ари-
ун Библи”-ээс авч бичсэн болно.

АМАР ТАЙВАН

© 2015 Жойс Майер

PEACE

ISBN 978-99973-0472-8

© 1995 by Joyce Meyer

Life In The Word, Inc.

P.O. Box 655 Fenton,

Missouri 63026

Peace

Mongolian

Олон Улсын Зохиогчийн Эрхийг Хамгаалах хуу-
лийн дагуу бүх эрх хамгаалагдсан. Зохиогчийн бичгэн
зөвшөөрөлгүйгээр энэ номын агуулга болон хавтасыг
бүхэлд нь болон хэсэгчилсэн хэлбэрээр дахин хэвлэ-
хийг хориглоно.

ГАРЧИГ



Өмнөх үг.....	5
1. Та амар тайвныг мэдэрч байна уу?.....	6
2. Амар тайвныг хэрхэн мэдрэх вэ?.....	9
3. Амар тайвнаар удирдуул.....	13
4. Таны амар тайвныг юу хулгайлдаг вэ?.....	17
5. Дяавол яагаад таны амар тайвныг хулгай- лахыг хичээдэг вэ?.....	21
6. Итгэгч хүн зовлон бэрхшээлийн дунд ямар байр суурьтай байх ёстой вэ?.....	30
7. Өнөөдрөөрөө амьдар.....	37
8. Залбирал танд амар тайвныг авчирдаг.....	45
Итгэлийн залбирал.....	50

ӨМНӨХ ҮГ

1 Петр 3:11-д:

“...Амар тайвныг хай, (зохицол, айдсаас үүсэх хямрал, сэтгэлийн шаналгаа болон ёс суртахууны зөрчилдөөн) түүнийг мөшгө (Бурхантай, найз нөхөдтэйгөө, өөрөө өөртэйгөө зүгээр л амар тайван харилцаатай байхыг хүсэх биш харин амар тайвныг олж ав, түүн рүү тэмүүл)”

“Бүх оюун ухааныг давах Бурханы амар тайван” (Филиппой 4:7) энэ номон дээрх амар тайван байдал таныг амар тайван баяр хөөртэй байхад туслаасай гэж залбирч байна.

ТА АМАР ТАЙВНЫГ МЭДЭРЧ БАЙНА УУ?

Иохан 14:27-д:

“Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай”.

Энэ үнэхээр хүчтэй, эрх мэдэлтэй ишлэл гэж би боддог. Энэ ишлэлийг хэд дахин уншаад, дараа нь дор хаяж таван минут хэртэй бясалгаж, оюун санаандаа шингээж авахыг би та бүхнээс хүсэж байна.

Есүс бидэнд энэ ертөнцийн өгдгөөс огт өөр, онцгой амар тайвныг өгдөг гэдгийг юуны түрүүнд тэмдэглэн хэлэх хэрэгтэй. Ертөнц бидэнд ямар амар тайвныг өгдөг вэ? Тэр бидэнд амар тайвны тухай тодорхой *мэдрэмжийг* л өгдөг Бүх зүйл таны хүссэнээр байгаа үед л та ертөнцийн өгсөн амар тайвныг мэдэрдэг. Харин бодож санасан зүйлс чинь хүссэнээр болохгүй үед энэ амар тайван яах

ийхийн зуургүй хулжин оддог. Гэтэл Есүсийн өгдөг амар тайван хүнд хэцүү цагт ч, аз жаргалтай үед ч тантай хамт байсаар л байдаг. Хүмүүс таныг орь ганцаар орхисон ч, таныг доромжлон гутаасан ч Есүсийн амар амгалан үргэлж тантай хамт байх болно.

Амьдрал чинь ямар ч асуудалгүй, бүх зүйл хүссэнээр чинь бүтэж байгаа үед таны сэтгэл санаа амар түвшин байдаг. Хэрэв ийм үед сэтгэл чинь тавгүйтвэл үнэхээр гайхалтай зүйл болж таарна. Бодит амьдрал дээр ийм зүйл болдоггүй гэдгийг бид амьдралынхаа туршлагаас мэдэх билээ. Би итгэгч хүнийхээ хувьд надад таалагддаггүй, буруу гэж бодсон аливаа зүйлийг бүгдийг нь итгэлээрээ засаж залруулах гэж олон жил хичээсэн. Үүнээсээ болоод сэтгэлээр унах, урам хугарах явдалд бишгүй ордог байлаа.

Хэзээ ч бүтэхгүй, бас чадахгүй юмыг хийх гэж оролдох нь эцэстээ бидний урмыг хугалахаас өөр юманд хүргэдэггүй. Харин Бурхантай харилцаатай болсныхоо дараа би амьдралын бэрхшээл зовлонг амар тайван, нам гүмхэн туулахад

өөрийнхөө итгэлийг хэрэглэх учиртай юм байна гэдгийг ойлгосон юм. Амар тайвныг минь цаг мөч бүрд хулгайлах боломжийг би диаволд гаргаж өгөхөө болих хэрэгтэй байлаа.

Иохан 14:27-д: “*Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай*” гэж Есүс хэлсэн байдаг. Би энэ ишлэлийг унших бүрдээ, тунгаан бодох болгондоо дээрх бүх зүйлийг зөвхөн өөрийнхөө төлөө хийгээд байна гэдгийг Библи надад байнга хэлж байсныг улам илүү ухаарсан юм. Би үүнийгээ болих хэрэгтэй байлаа. Есүс энэ ишлэлд “*Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай*” гэж хэлсэн.

Марк 4:40-р ишлэлд Есүс далайн шуурганаас айж сандарсных нь төлөө шавь нараа буруутгасан байдаг. Харин Есүс огт сандраагүй бөгөөд маш тайван байсан. Тэрээр завины арын хэсэгт унтаж байсан. Түүний шавь нар маш их сандарч, сэтгэлээр унасан байсан.

Хэрвээ та тэнд байсан бол яах байсан бэ? Та завины арын хэсэгт Есүстэй хамт амар тайван байх байсан уу?

Хэрэв таны дотор амар тайван байхгүй бол та амьдралын сайхныг мэдрэхгүй.

АМАР ТАЙВНЫГ ХЭРХЭН МЭДРЭХ ВЭ?

Танд хэрэгтэй зүйлийг “хэрхэн” олж авах талаар зарим нэг заавар зөвлөгөөг өгөөгүй бол ямар ч мэдээ ашиг тустай байж чадахгүй. Надад амар тайван хэрэгтэй байна гэж хэлэх нь эхний алхам. Гэхдээ тэрхүү амар тайвныг хэрхэн олж авч болохыг бодит амьдрал дээр хуваалцахгүйгээр жинхэнэ үр жимс гарахгүй.

Амар тайван амьдралаар амьдарч эхлэхэд маань надад нэг зүйл маш их тус болсон. “Өөрийнхөө хүч хүрэхгүй зүйлд оролцож, ямар нэг зүйл хийх гэж хичээх” нь үр ашиггүй бөгөөд урмыг минь хугалж, сэтгэлээр унагахаас өөр цаашгүй гэдгийг би ойлгосон юм. Та ч бас тэгдэг үү? Ямар нэг зүйлийг өөрийнхөөрөө өөрчлөх гэж хичээсээр та бүр сэтгэлээр унаж орхидог уу? Бүх зүйлд Бурханы товлосон төгс цаг гэж байдаг. Тиймээс та Түүний товлосон цагийг хүлээх хэрэгтэй.

Ерөнхийдөө, та цаг нь болохоос өмнө ямар нэг зүйлийг хийж чадахгүй. Хий-

дэг байлаа ч та түүнээс баяр хөөр, аз жаргалыг мэдрэхгүй. Тиймээс Бурханыг хүлээж сур. Энэ нь Бурханд хүндэтгэлийг, харин танд амар тайвныг авчрах болно.

Та боломжгүй зүйлийг хийх гэж хичээж байна уу? Хань ижил, үр хүүхэд, найз нөхөд, хамаатан садан гэх мэтчилэн эргэн тойрондоо байгаа хүмүүсийг өөрчлөх гэж та хичээсээр байна уу? Тэгвэл хүн хүнээ өөрчилж чаддаггүй гэдгийг би танд хэлмээр байна. Зөвхөн Бурхан л хүмүүний зүрх сэтгэлийн гүнд нэвтэрч, өөрчлөгдөх хүслийг түүнд төрүүлж чаддаг. Хэрэв бид хүнийг шахаж шаардаж, гаднаас нь хүчлэх аваас энэ нь эцэстээ түүний амар тайвныг хулгайлахаас өөр үр дүнд хүргэхгүй. Бурхан биднийг хуулийн дор байлгах гэж бүтээгээгүй. Хүмүүст эрх чөлөө хэрэгтэй. Тэдэнд чөлөөтэй хөдлөх орон зай хэрэгтэй.

Би Дэйвтэй гэрлэснийхээ дараа эхний хэдэн жил түүнийг гольф тоглохыг нь болиулах гэж янз бүрээр оролдсон. Би аль болох түүнтэй хамт байхыг хүсдэг байлаа. Харин тэр гольф тоглоход хамаг цагаа зарцуулаад байх шиг санагддаг байв.

Түүнийг тоглуулахгүйн тулд би өөрийн мэддэг бүхий л арга ухаан, заль мэхээ хэрэглэсэн. Би гомдож ч үзлээ, уурлаж ч үзлээ, бас ятгаж сэнхрүүлэх гэж ч оролдсон. Тэр ч байтугай унтуулах эм хүртэл өгч үзсэн. Гэвч аль аль нь огт тус болоогүй. Тэр тоолонгоор миний урам хугарч байлаа. Заримдаа Дэйв хэсэг хугацаанд тоглохоо больдог ч хамгийн гайхалтай нь хүссэндээ хүрлээ гээд миний сэтгэл амардаггүй байв. Учир нь би хүслээ гүйцэлдүүлэхийн тулд буруу арга зам хэрэглэсэн болохоор сэтгэл минь тайван байж чаддаггүй байлаа. Хэрэв та хэн нэгнийг өөрчлөх гэж хичээж байгаа бол энэ нь таны амар тайвныг хулгайлах болно.

Та сүнсний хувьд байх ёстой газраа байхгүй байгаа учраас өөртөө сэтгэл дундуур, урамгүй байна уу? Та өөрийгөө өөрчлөхийг хүсэж байна уу? Тэгвэл та таны амьдралд ажиллаж буй Ариун Сүнснэ тэй хамтран ажилла. Тэр танд төгс байдал болон төлөвшлийг авчрахын төлөө ажилладаг билээ. Та өөрөө ийм хэмжээнд хүрч чадахгүй. Энэ бол таны хийж чадахгүй атлаа хийхийг хичээдэг өөр нэг зүйл юм.

Өөртөө таалагдахгүй байгаа зүйлийг өөрчлөх гэж хичээх нь хэнд ч байх ёстой ердийн зүйл гэж та лавтай бодож байгаа байх. Гэхдээ та энэ асуудлыг жаахан бодитой авч үзэхийг хичээгээрэй. Та тиймэрхүү зүйлийг хэр амжилттай өөрчилж байсан бэ? Таны амьдралд учирсан хүмүүс болон өөрийнхөө төлөө та Бурханд найдан, Түүний товлосон цагийг хүлээн, Түүний дотор амарч суухын оронд өөрийнхөө урмыг хугалж, амар тайвнаа алдаж байна уу?

Одоо ингээд энэ бүлэгт уншсан зүйлээ хамтдаа дүгнэе: хэрэв та “өөрийн хүч хүрэхгүй, хийж чадахгүй, ямар ч боломжгүй зүйлийг хийх гэж хичээж” байгаа бол удахгүй таны урам хугарч, ямар ч амар тайвныг мэдрэхгүй болно.

АМАР ТАЙВНААР УДИРДУУЛ

Колоссай 3:15-д:

*“Христийн амар тайван та
нарын зүрх сэтгэлийг захираг...”*

Спорт тоглоомын үед шүүгч таныг талбайн дотор байна уу эсвэл, гадна байна уу гэдгээр шүүдэг. Тэгвэл таны амьдралын дотор болон гадна байх ёстой зүйлийг тодорхойлдог шүүгч нь амар тайван юм.

Олон хүн Бурханы хүслээс гадна байдаг учраас амар тайвныг мэдэрдэггүй. Тэд Бурханы хүслээс илүүтэй өөрсдийнхөө хүслийг дагадаг. Тэд Бурханы Үгийг дагаж, амар тайвнаар удирдуулахын оронд өөрсдийн таалалд нийцүүлж, зөв гэж үзсэнээ үйлддэг. Бидний хийх дуртай, хийхийг хүсдэг зүйл гарч ирэх тохиолдол олон. Ийм зүйлс бидэнд сайхан сонсогдож, бас сайхан санагддаг. Магадгүй тэр нь сайн зүйл ч байж болно. Гэхдээ хэрэв түүнийг хийхэд миний сэтгэл тайван биш бол ямар ч сайхан зүйл байсан

орхиж сурах хэрэгтэй. *Амар тайвнаар удирдуул.* Та ямар нэг зүйл худалдан авах гэж байгаа бол, ялангуяа томоохон зүйл худалдаж авах үед, хэрэв таны сэтгэл тайван биш байвал тэр зүйлийг худалдаж авах хэрэггүй. Хэдийгээр та түүнийг авахыг маш их хүсэж байсан ч, хэрэв Ариун Сүнсний удирдамжийн эсрэг байгаа бол түүнээс татгалзах хэрэгтэй.

Заримдаа надад энд тэнд үг хэлэх урилга ирдэг юм. Уул нь би ийм урилгыг хүлээн авах дуртай хэрнээ хүлээж авсныхаа дараа заримдаа яагаад ч юм сэтгэл нэг л түгшүүртэй болоод явчихдаг юм. Ийм урилга ирэхэд шууд л хүлээн авмаар санагддаг ч миний сэтгэл амар тайван байгаа эсэхийг хамгийн түрүүнд анзаарах ёстой гэдгийг би эцэст нь ойлгосон.

Орон нутгуудаар явж номлодог болоод удаагүй байхад ирсэн нэг ийм урилгыг би тодхон санаж байна. Тэр үед надад ийм урилга их цөөхөн ирдэг байсан. Үнэндээ бол би ирсэн урилга болгоныг алдалгүй хүлээж авахыг хүсдэг байлаа. Тэр үед надад Техасын нэгэн чуулганд номлох урилга ирсэн юм. Би түүнийг маш ба-

яртайгаар хүлээн авсан. Харин хоёр долоо хоног өнгөрсний дараа тийшээ явах тухай бодох бүр миний дотор хачин ихээр шаналах болов. Тэр шаналал өдрөөс өдөрт улам хүчтэй болж байлаа. Тийшээ явах тухай бодох болгонд сэтгэл түгшсээр, харин яагаад гэдгийг Бурхан надад хэлэхгүй л байв.

Би Бурханаас хариу хүлээсээр л байв. Тэгээд эцэст нь, би тэдэн уруу утасдаж, энэ үүргээс чөлөөлж өгөхийг хүсэх хэрэгтэй юм байна гэдгийг ойлгосон. Тийнхүү би тэдэн уруу утсаар ярьж, ямар нэг шалтгаанаар сэтгэл тавгүйтээд байгаагаа учирлаад, хэрэв оронд минь номлох хүн олдохгүй бол очье гэж хэлсэн юм. Тэгээд тэд намайг тэр үүргээс чөлөөлж билээ.

Түүнээс хойш хэдхэн долоо хоногийн дараа, намайг Техас уруу явах ёстой байсан тэр өдөр төрөлх чуулган маань шинэ барилгынхаа нээлтийг хийх гэж байгаа тухай би сонсов. Би одоогийнхоо энэ үйлчлэлийг эхлэхээс өмнө чуулганыхаа туслах пастор байсан тул энэ арга хэмжээнд оролцох нь миний хувьд тун чухал байлаа.

Юу болох гээд байгааг Бурхан надад яагаад шууд хэлээгүй юм бол? Зарим шалтгааны улмаас Бурхан ингэж шууд хэлдэггүй аж. Амар тайвнаар удирдуул гэж Түүний Үгэнд хэлсэн байдаг. Таныг Бурханы хүслийн гадна байна уу, дотор байна уу гэдгийг тань мэдүүлэхийн тулд л Бурхан танд амар тайвныг өгдөг. Харин яагаад гэдгийг нь хожим та мэдэж ч болно, огт мэдэхгүй өнгөрч болох юм.

Хэрэв та Түүний удирдамжид дуулгаваргүй хандаж, өөрийн хүслийг дагах аваас амар тайван амьдралын сайн сайхныг хэзээ ч амсаж мэдрэхгүй.

ТАНЫ АМАР ТАЙВНЫГ ЮУ ХУЛГАЙЛДАГ ВЭ?

Хүн бүрд санаа зовнидог зүйл байдаг. Таныг судалж тандахад сатан хамаг амьдралаа зориулдаг учраас таныг өөрөөс тань илүү мэддэг. Таны сэтгэлийг юу зовоодгийг тэр сайн мэднэ. *Тиймээс сэтгэлийг тань юу хамгийн ихээр зовоодгийг та өөрөө мэдэж аваад*, сэтгэл зовсон үедээ амар тайвнаа алдахгүй байхад анхаарах хэрэгтэй.

Хүн бүрийн хувьд “амар тайвныг хулгайлагч” нь өөр өөр зүйлс байдаг. Миний сэтгэлийг шаналгадаг зүйл Дэйвийн хувьд тэгтлээ зовоод байхаар зүйл биш байх жишээтэй. Жишээ нь, би чимээгүй, нам гүм орчинд дуртай байхад, Дэйв дуу шуугианаас огт төвөгшөөдөггүй. Охин маань хөгжмөө хамгийн чанга дээр тавьсан, есөн настай хүү маань нохойтойгоо ноцолдож байхад ч Дэйв хээв нэг ном уншаад сууж байдаг юм.

Би яарч сандрахыг үздэггүй, хоцрохыг бүр тэвчдэггүй. Харин Дэйв оногдсон цагт

дэндүү их зүйлийг амжуулах гэж хичээдэг. Тийнхүү бид эцсийн мөчид байдгаараа яарч сандран хийж дуусгадаг. Дявол миний энэ сул талыг сайн мэддэг учраас амар тайвныг минь хулгайлахын тулд үүнийг хэрэглэх нь дамжиггүй. Харин Дэйвийн хувьд, тэрээр хаа нэг тийшээ нисэх гэж байгаа бол онгоцны буудал дээр нисэх цагаасаа дор хаяж цагийн өмнө очихыг эрхэмлэдэг. Гольф тоглохоор явахдаа цагаасаа түрүүлээд оччихно. Хэрэв дявол түүнийг ямар нэг арга хэмжээнээс хоцроох зүйл хийвэл түүний сэтгэл тайван биш болж эхэлдэг.

Бид бүгдээрээ бие биеэсээ ялгаатай, өөр хүмүүс. Тиймээс сатан бидний хүн нэг бүртэй өөр аргаар ажилладаг. Тэгэхлээр бид түүнээс ухаалаг байх хэрэгтэй юм. *Тэр таныг сэтгэлээр унагахын тулд бүхнийг хийдэг.* Таны “амар тайвныг бусниулж”, сэтгэлийг чинь зовоодог зүйл юу вэ? Тэдгээр зүйлээ жагсаан бичээд, гэр бүлийнхэнтэйгээ ярилцаарай. Тэгээд тэдний дургүйг хүргэж, бухимдуулдаг зүйлийг олж мэдээд, тэдгээрээс зайлсхийхэд нь бие биедээ туслаарай.

Дэйв маш сайн гольфчин. Харин миний хувьд, гольф тоглохын хувьд тоглодог ч талбай дээр энэ тэр хүнийг харж доог тохуу хийх нь илүү таатай санагддаг байлаа. Дэйвтэй хамт тоглохоор оччихоод, хийх юмаа олж ядан, түүнийг алдаж цохих тоолонд нь шоолж тохуурхах нь тийм ч ухаалаг явдал биш гэдгийг би хожим ойлгосон. Хэдийгээр бид хамтдаа хөгжилтэй байдаг ч, би түүний тав тухыг алдуулах биш, харин ч аль болох таатай сэтгэгдэл төрүүлэх хэрэгтэй байсан юм. Хэн нэгний тайван байдлыг алдагдуулж, сэтгэлийг нь зовоох ямар хэрэгтэй юм бэ? Та хэн нэгэн хүнтэй удаан хамт амьдрах тусам түүний төдийгүй өөрийнхөө сул талыг мэдэж эхэлдэг. “Тэр зүйлээсээ зайлсхийхэд нь бие биедээ туслахыг хичээх хэрэгтэй” гэдгийг би дахин хэлье.

Миний сул тал дээр Дэйв надад анхаарал халамж тавьж, надад тусалдаг. Намайг юм уншиж судалж байхад, мөн амарч байхад Дэйв аль болох чимээгүй, намгүм орчинг бүрдүүлж өгөхийг хичээдэг. Дэйв намайг сайн амарч, алжаал ядаргаагаа тайлж ав гэж үргэлж ятгадаг. Уч-

ир нь хэт ядарсан үед маань сатан миний тайван амгалан байдлыг хулгайлдаг гэдгийг тэр сайн мэддэг. **Галат 6:2-д:** **“Нэг нэгнийхээ ачаанаас үүрэлц...”** гэж хэлсэн байдаг. Тиймээс бид бие биенийхээ сул талыг үүрэлцэж, бие биенийхээ төлөө залбирах хэрэгтэй юм. Учир нь бидэнд маш олон сул тал бий.

ДИАВОЛ ЯАГААД ТАНЫ АМАР ТАЙВНЫГ ХУЛГАЙЛАХЫГ ХИЧЭЭДЭГ ВЭ?

Амар тайван байдал биднийг Ариун Сүнстэй холбож өгдөг гэдгийг бид мэднэ. Өөрөөр хэлбэл, Ариун Сүнс зөвхөн амар тайван нөхцөлд л ажилладаг гэж хэлж болно. *Амар тайван хаана байна, тэнд хүч оршдог.* Есүсээс бидний хүлээн авсан өв бол амар тайван мөн хэмээн **Иохан 14:27**-д өгүүлсэн байдаг. Би үүнд итгэдэг. *“...Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна...”* Өөрөөр хэлбэл, Тэр биднийг Өөрийнх нь амар тайвныг хүлээн аваасай гэж хүсдэг.

Хэрэв та асуудал тулгарахад амар тайван байдлаа хадгалан, сэтгэлээр унахгүй байж чадаж байгаа бол диаволд таныг ялан дийлэх хүч алга байна гэсэн үг. Зовлон бэрхшээл дунд биеэ барьж, тайван амгалан байж, итгэл найдвараа хадгалж байгаагаар тань таны хүч илэрхийлэгдэх бол-

но. Ийм тохиолдолд диаволын хүч таныг сэтгэлээр унагаж, айдаст автуулж дийлэхгүй.

Бэрхшээл тулгарах үед хамгийн гол нь тайван амгалан байхыг зорилгоо болгох хэрэгтэй. Сандарч тэвдэж, өөрийгөө диаволын хамтран тоглогч болгох хэрэггүй. Тэр таныг сэтгэлээр унахад бах нь ханаж, баярлан дэвхэцдэг. Дийлэнх хүний хувьд сэтгэл санаагаар унасан үедээ санаанд орсноо ямар ч хяналтгүй гаргах хандлагатай байдаг. Бидний амнаас гарсан бодлогогүй үг эргээд диаволд олз болж, тэрээр дөнгөж асаад байгаа галд тос нэмэн өрдөж орхидог.

Иаков 3:5–6-р ишлэлд, хэл хэдийгээр жижиг эрхтэн боловч асар их түймрийг шатаах чадалтай гэж хэлсэн байдаг. Хэл бол хорт муу явдлын уурхай бөгөөд бидний эрхтнүүдийн дунд байж бүх биеийг бузарлан, өөрөө тамаар асаж байдаг гэж дээрх ишлэлд хэлдэг. Энэ ишлэлээс харахад, диавол таныг биеэ барих чадваргүй болж, бүх хяналтаа алдахыг хүлээж байдаг агаад тэгснээр тэр өөрөө таныг удирдах боломжтой болдог аж. *Диавол таныг*

сэтгэлээр унагахын тулд бүхнийг хийдэг гэдгийг бүү мартаарай.

Чуулганд явах, Библи судлалын хичээлд очих гэхээр л диавол бүр илүү идэвхтэй ажиллаад эхэлдгийг та анзаарсан байх. Ням гарагийн өглөө манай гэрт бөөн асуудал ундардаг байлаа. Нэлээд олон жил ийм байсан шүү. Манай гэрийнхнээс хэн нэг нь сэтгэлээр унахгүйгээр чуулгандаа явж байсан удаа тун ховор.

Бусад өдөр гайгүй байдаг хэрнээ ням гарагийн өглөө заавал ч үгүй хэн нэг нь ямар нэг юмаа эрээд олохгүй болох юмуу, эсвэл барьж байсан юмаа алдаж асгах, аль эсвэл ямар нэг зүйл эвдэрч хэмхэрдэг байж билээ. Хүүхдүүд маань долоо хоногийн бусад өдрүүдэд зүв зүгээр байцгаадаг хэрнээ ням гарагийн өглөө хоорондоо хэрэлдэж муудалцана. Тийнхүү дуу шуугиан нэмэгдэх тусам миний сэтгэл улам их тавгүйтнэ. (Дуу чимээтэй орчинд дургүй гэж хэлж байсныг минь та санаж байгаа байх.)

Тэгээд эцэст нь би тэсэхгүй гомдоллож эхэлнэ. Харин Дэйв гомдоллож яншихыг тэвчиж чаддаггүй учраас намайг

дуугүй болохыг шаардана. Ингэж хэлснийх нь төлөө би түүнд уурлана. Харин ийнхүү маргалдаж байгаа эцэг эхээ хараад хүүхдүүд маань уйлалдана.

Энэ бүхний хажуугаар нохой маань хэн нэгнийх нь гутлыг хөлдөө чирэн гүйх зуурт би тэсгэлгүй: “За алив, түргэлээч ээ! Хоцорлоо шүү дээ!” гэж хашхирна. Энэ дүр зураг танд ч гэсэн танил санагдаж байгаа гэдэгт би итгэлтэй байна.

Бурханы Үгийг сонсохоор явах гэж байх үед яагаад иймэрхүү саад гарч ирээд байдгийн учрыг **Иаков 3:18-ыг** уншаад би ойлгосон юм. Энэ ишлэлд: **“Үр жимс нь зөв байгчийн үр нь амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг”** гэж хэлсэн байдаг.

Өөрөөр хэлбэл, Бурханы Үг бидний амьдралд гүн үндэслэгдэж, сайн үр жимс ургуулахын тулд түүнийг зааж, тунхаглаж байгаа хүн нь амар тайвныг бүтээгч байх ёстой аж. Түүнчлэн Үгийг сонсож байгаа бид ч бас амар тайван дотор байх хэрэгтэй.

Та өөрийнхөө амьдралыг эргээд нэг харахгүй юу. Бурханы Үгийг сонсохоор

гарах гэж байхад чинь диавол таны урмыг хичнээн удаа хугалж, сэтгэлийг чинь үймүүлж байсан бэ? Түүний төлөвлөгөөнд сэрэмжтэй байж, урхинд нь дахин орохгүй байх хэрэгтэй.

2 Коринт 2:11-д: *“Сатаны заль мэх, хөнөөлт санааг бид ямар мэдэхгүй биш”* хэмээсэн байдаг. Сатан биднийг төөрөгдүүлж, мэхлэхийн тулд бүхий л арга залиа хэрэглэдэг. Тиймээс бид түүнээс илүү ухаалаг байх хэрэгтэй юм.

1 Петр 5:8-д: *“Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй бай. Та нарын өрсөлдөгч болох диавол нь хэн нэгнийг залгихаар хайж буй архирах арслан мэт гэсэн явдаг”* гэсэн байдаг.

Таныг залгих боломжийг түүнд бүү тавьж өг! Би таныг болгоомжтой, сонор сэрэмжтэй байгтун хэмээн уриалж байна. Сэтгэлээр унаж, арга мухардах болгондоо “Диавол яг юу хийхийг хүсээд байна вэ? Хэрэв би энэ сөрөг сэтгэгдлээ өөгшүүлээд байвал үүнээс ямар үр дагавар гарч болох вэ?” гэж өөрөөсөө асууж байгаарай.

Бидний амьдралыг удирдах боломжийг диаволд өгөхгүй байхын тулд сэт-

гэлээр унахгүй байх хэрэгтэй бөгөөд хэрхэн ингэж сурах талаар **Ефес 4:26–27-р** ишлэлд маш тодорхой хэлсэн байдаг. **26-р** ишлэлд: **“Та нарын уур хилэн дээр нар бүү жаргаг”** гэжээ. Өөрөөр хэлбэл, “Сэтгэлээр унасан бол тэр хэвээрээ удах хэрэггүй” гэж хэлж байна.

27-р ишлэлд: **“Диаволд байр бүү өг”** гэсэн нь амьдралд чинь эзэн суух боломжийг диаволд бүү гаргаж өг гэсэн утгатай ажээ. Та сэтгэлээр унах үедээ амьдралын баяр баяслаа гээж орхидог. Амьдралын баяр баясгалангүй болсон та ямар ч хүч чадалгүй болдог. **Нехемиа 8:10-д**: **“Эзэний баяр баясгалан бол та нарын хүч чадал юм”** гэсэн байдаг **Дуулал 42:5-д**: **“Сэтгэл минь ээ, ...яагаад чи миний дотор үймүүлэгдэнэ вэ?”** гэж дууллыг бичигч хэлжээ. Мөн **Исаиа 30:15-д**: **“Үнэнч итгэл ба чимээгүй байх нь та нарын хүч мөн”** гэсэн байдаг. Тэгэхлээр диавол бидний хүч чадлыг хулгайлахын тулд бидний сэтгэлийг тавгүйтүүлж, үймүүлэхийг хүсдэг гэдгийг бид эдгээр ишлэлээс олж харлаа.

Ариун Сүнс амар тайван дунд ажилладаг гэдгийг би Түүнээс Өөрөөс нь сур-

сан. Тэрээр уур бухимдал дунд ажилладаггүй. Диавол уур бухимдал дунд ажилладаг бол, Ариун Сүнс амар тайван дунд ажилладаг. Тиймээс гэр бүл, ажил үйлчлэл, сүм чуулган дээрээ амар тайван уур амьсгалыг бүрдүүлэх хэрэгтэй. Хэрэв тэгж чадвал та Бурханы Үг болон Ариун Сүнсэнд хүндэтгэл үзүүлж буй хэрэг юм. Тийнхүү та дуулгавартай байдлынхаа үр жимсийг хураах болно. Есүс чөтгөрүүдийг зайлуулж, Сайн мэдээг тунхаглуулж, өвчтэй хүмүүсийг эдгээлгэхээр далан хүнийг хоёр хоёроор нь илгээсэн түүхийг та санаж байна уу? Есүс тэднийг очсон хотынхоо ямар ч айлаар орсон эхлээд амар тайвныг ерөөгөөд, хэрэв тэр айл өөрсдийг нь амар тайвнаар хүлээн авбал тэндээ бай, харин хүлээж авахгүй бол хөлдөө наалдсан тоосыг гөвөөд, цаашаа яв гэж хэлсэн байдаг (Лук 10:1–11, 17). Яагаад? Яагаад гэвэл, тэр газар тэднийг амар тайвнаар хүлээн авахаас нааш тэдний ажил хүчгүй байх учраас тэр аж.

Энэ номоороо дамжуулан миний хэлэх гэсэн санаа одоо танд тодорхой болж байгаа байх гэж найдаж байна. *Үргэлж*

амар амгалан байхын тулд биеэ захирахад өөрийгөө дадлагажуулахын төлөө чадах бүхнээ хий.

Лук 22:46-д биднийг сорилтод орохгүйн тулд залбирах хэрэгтэй гэж сургасан байдаг. Тэрээр Өөрийнхөө шавь нарт: **“Босоцгоо, сорилтод орохгүйн тулд та нар залбирицгаа”** гэж айлдсан. Та энэ талбарт диаволыг эсэргүүцэхдээ өөртөө болон өөрийнхөө хүчинд найдах хэрэггүй. Диавол таны амар тайвныг бусниулахаар довтлох үед түүнийг эсэргүүцэх нигүүлслийн төлөө Бурханаас өдөр бүр залбиран гуй. Таныг хүчирхэгжүүлж, танд туслахыг Эзэнээс гуйгаарай.

Иохан 15:5-д: **“Учир нь Надаас салангад байвал та нар юу ч хийж чадахгүй”** хэмээн Есүсийн хэлснийг санагтун. Тиймээс аливаа зүйлийг өөрийнхөө хүчээр хийх гэж бүү оролд! Харин Бурханаас тусламж гуй. Та Христээр дамжуулан бүгдийг хийж чадна (**Филиппой 4:13**), харин өөрийнхөө хүчээр та юу ч хийж чадахгүй. Тэр ч байтугай Есүс Өөрийгөө **Иохан 5:30-д:** **“Би Өөрийн санаагаар юуг ч үйлдэж чадахгүй”** гэж хэлсэн байдаг. Хэрэв

та Бурханы тусламжийг авахыг хүсэж байгаа бол даруу хандлагатай байх ёстой.

1 Петр 5:5-д: “Бурхан бардам хүнийг эсэргүүцдэг, харин даруу хүнд ниүүлслээ өгдөг” гэсэн байдаг.

Ингээд энэ бүлгийг эцэст нь дүгнээд хэлэхэд, сатан таны хүч чадлыг хулгайлахын тулд амар тайвныг чинь хулгайлахыг хүсдэг аж. Тэр таныг хүчгүй, сул дорой байлгахыг хүсдэг. Харин би таныг: **“...Эзэн дотор ба Түүний чадлын агуу хүч дотор бэхжигтүн” (Ефес 6:10)** гэж уриалмаар байна. *Амар амгалан байгтун!*

ИТГЭГЧ ХҮН ЗОВЛОН БЭРХШЭЭЛИЙН ДУНД ЯМАР БАЙР СУУРЬТАЙ БАЙХ ЁСТОЙ ВЭ?

Ефес 6:13-д:

“...бүхнийг хийсний дараа, бат зогсох чадвартай байхын тулд (өөрийн байрандаа бат зогсох)”.

“Учир нь бид – Христ Есүс дотор бүтээгдсэн. Түүний бүтээл мөн... та нар эдүгээ Христ Есүс дотор...” (Ефес 2:10, 13). Уг ишлэлд бид Христийн дотор байдаг гэж бичсэн байна. *“Хэрэв та нар Миний дотор, Миний үгс та нарын дотор байвал та нар юу хүссэнээ гуй. Тэгвэл та нарын төлөө биелэх болно”* гэж Есүс хэлсэн (Иохан 15:7).

Өөрөөр хэлбэл, хэрэв та нар Христ дотор байвал хүчтэй байх болно гэсэн үг юм.

Сэтгэлийг чинь зовоосон асуудлуудаа орхиод, харин Бурханы амралт уруу орохын тулд итгэл ба дуулгавартай байд-

лаараа хичээн зүтгэ, тэгвэл чи Түүний амралт уруу *орох болно* гэж (**Еврей 4:10**) хэлсэн байдаг. Зовлон бэрхшээл тулгарах үед Бурханы удирдамжийг дуулгавартай даган, Христ дотор байж, Тэр таны төлөө юу хийхийг ажиглан хар. **“Бат зогсож, ЭЗЭНий авралыг харцгаа”** гэж Библи хэлдэг (**Египетээс гарсан нь 14:13**). *Бат зогс, бай, зогс, амар* – гэсэн энэ үгс бүгд нэг л гол зүйлийг хэлж байна; тэр бол: *Амар тайвнаа бүү алд!* Гэсэн үг болой.

Филиппой 1:28 ишлэлийг би Библийн хамгийн хүчтэй ишлэлүүдийн нэг гэж боддог. Энэ ишлэлд дээрх санааг маш тодорхой, маш хүчтэй гаргаж өгсөн байдаг.

“Мөн эсэргүүцэгчдийн юунаас ч айж сүрдэхгүй байгааг чинь би сонсох болно. Тэгээд ч айж сүрдэхгүй байх нь тэдний хувьд сүйрлийн тэмдэг, харин та нарын хувьд авралын тэмдэг юм. Энэ нь Бурханаас ирдэг юм” гэж энэ ишлэлд хэлсэн байдаг.

Өөрөөр хэлбэл, *хэрэв та нарт эсэргүүцэл тулгарвал айж сандралгүй, амар тайван байгтун* гэж энд маш тодорхой

хэлж байна. Хэрэв та тийм байж чадвал диавол танд ялагдах болно. Тэр таныг сэтгэлээр унагаж чадахгүй бол дараа нь ямар алхам хийхээ мэдэхгүй мухарддаг. Түүнчлэн амар тайвнаа алдахгүй байгаа нь таныг Бурханы авралыг хүлээн авсныг илтгэн харуулдаг. Учир нь таны энэ хандлага таныг жинхэнэ итгэлээр үйлдэж буйг тань Бурханд гэрчилдэг. Бурханы амралт уруу ордог хүмүүс итгэлийг хүлээн авсан хүмүүс байдаг гэж **Еврей 4-р** бүлэгт хэлдэг.

Бурхан таны асуудлын дээр ажлаа хийж байх зуур та амьдралын сайхныг мэдэрч, урагшаа урам зоригтой алхагтун. Асуудалтай байж яаж өөртөө сэтгэл хангалуун явах вэ дээ гэж ихэнх хүмүүс боддог. Гэтэл, та ямар нэг зүйл хийхгүй л юм бол сэтгэлээр унаж, гутрахаас өөр сайн үр дүн гарна гэж үү?

Өнгөрсөн он жилүүдэд надад ч бас иймэрхүү бодол төрж байсан удаа олон. Мэдээж Дэйв бид хоёрт янз бүрийн л асуудал, бэрхшээл тулгарч байсан. Тэр болгонд Дэйв аз жаргалтай, баяр хөөртэй байж чаддаг байлаа. Харин би сэтгэ-

лээр унаж, надтай хамт шаналахгүй байгаад нь түүнд уур хүрдэг байсан.

Бидэнд тулгардаг асуудлын ихэнх нь санхүүгийн асуудал байдаг. Мөнгө санхүүгийн тал дээр Дэйв ер бусын итгэлтэй байх шиг санагддаг юм. Тэрээр: “бид аравны нэгээ өргөдөг, хүмүүст өгөөмөр ханддаг. Бурхан: **“...та нарын төлөө санаа тавьдаг учраас бүх зовнилоо Түүнд үүрүүл” (1 Петр 5:7)**, Бурхан биднийг хэрэгтэй бүхнээр хангана (**Филиппой 4:19**) гэж Библид хэлсэн. Тийм атал бид яагаад үүнд санаа зовох ёстой гэж? Санаа зовлоо гээд мөнгөтэй болчихгүй шүү дээ” гэж хэлдэг.

Дэйв ийм л байр суурин дээр “зогсдог”. Бурхан бидний асуудал дээр ажиллаж байх зуур Дэйв амьдралын сайхныг эдэлж, урагшилсаар байдаг. Би түүнд: “Дэйв минь, би наадхыг чинь сайн мэдэж байна. Гэхдээ чи юу ч хийхгүй, зүв зүгээр суугаад байж болохгүй биз дээ?” гэж хэлнэ. Би түүнийг ямар нэг юм хийгээсэй гэж хүсдэг. Харин тэр хариуд нь надаас: “За яахав, чи тэгээд надаар яг юу хийлгэмээр байгаа юм бэ дээ?” гэж асууна. Тэ-

гэхэд нь би: “Залбир! Чи залбирах ёстой шүү дээ” гэнэ. Харин тэр: “Би залбирсан. Энэ асуудалд санаа тавьж өгөөч; хэрэв миний хийх ёстой зүйл байгаа бол надад харуулаач гэж Бурханаас гуйсан. Одоогоор Тэр надад ямар ч зүйл харуулаагүй л байна. Тийм болохоор сэтгэлээр унаад, гутраад байх зүйл алга” гэж хариулна.

Дэйвийн зөв гэдгийг сэтгэлийнхээ мухарт би мэдээд байгаа хэрнээ ийм асуудалтай байж яаж баяр жаргалтай байх вэ дээ гэсэн нэгэн гундуу бодол дотроос хатгаад болдоггүй байлаа. Бид олон жилийн турш ийм байдалтай явсан. Асуудал тулгарахад Дэйв залбирна, тэгээд амар тайван амьдарна, харин би залбирна, тэгсэн хэрнээ санаа зовсон хэвээр үлдэнэ. Ингэж би өөрийгөө аз жаргалгүй хүн болгож хувиргадаг байв. Харин Дэйв амьдралын сайхныг мэдэрч, бас эдэлсээр л. Эцсийн мөчид Бурхан бидний залбиралд хариулдаг байсан.

Би санаа зовсноороо юуг ч өөрчилж чадахгүй гэдгийг эцэст нь ухаарсандаа Бурханд талархаж байна. Би дэмий л өөрийгөө шаналгаж, магадгүй, үүгээрээ

Бурханы бидэнд зэхсэн хариултыг хойшлуулж орхидог байсан байх. Харин одоо би *далайн хүчит салхи шуурч байсан ч амар амгалан* байж чаддаг болсон (**Марк 4:37–40**).

“Ертөнцөд та нар зовлонтой байна. Гэвч зоригтой байгтун. Би ертөнцийг ялсан” (**Иохан 16:33**) гэж Есүс хэлсэн. Сорилт ирэх нь гарцаагүй, харин түүнд уруу татагдахгүй байх хэрэгтэй гэж Библи бидэнд сургадаг (**Лук 8:13, 1 Коринт 10:13, Иаков 1:12**). Бидний амьдралд асуудал бэрхшээл, зовлон зүдгүүр тулгарах нь гарцаагүй, харин бид тэр бүхнийг Христ Есүсээр дамжуулан даван туулна гэж би итгэдэг. Бид бол Түүгээр дамжуулан давуулан дийлэгчид билээ (**Ром 8:37**).

Бид зөвхөн нэг удаа *давуулан дийлсэн хүмүүс* биш, харин бид *үргэлж давуулан дийлэгчид* билээ. Та өмнө нь тулгарч байсан саад бэрхшээлүүдээ даван туулсан тэр түвшинд хүрч очихгүй байлаа ч Христ дотор ялан дийлнэ гэсэн бат итгэл таны дотор үргэлж байх болно. Та үргэлж давуулан дийлэгч байх болно!

Паулын хүрч очсон тэр түвшинд та ч мөн хүрэх ёстой. **Филиппой 4:11–12**-д Паул: “*би тарчигхан ч байсан, элбэг дэлбэг ч байсан, ямар ч нөхцөлд сэтгэл хангалуун байж сурсан*” гэж хэлсэн байдаг. Та ч бас үүнд суралцахгүй бол таны амьдрал ар араасаа хөвөрсөн сэтгэлийн гутралаар дүүрэх болно. Хэрэв диавол таныг нөхцөл байдлаар чинь дамжуулан удирддаг болчихвол насан туршид чинь таныг боолчилно гэдгийг үргэлж санаж явах хэрэгтэй. Харин та үргэлж амар тайван дотор алхсанаар эрх мэдэлтэй байж чадна.

ӨНӨӨДРӨӨРӨӨ АМЬДАР

Матай 6:34-д:

“Тиймээс маргаашийн төлөө бүү санаа зов. Учир нь маргааши маргаашидаа санаа тавих болно. Өдөр бүрийн зовлон тухайн өдөртөө хангалттай”.

Бидний амгалан тайван байдлыг алдагдуулж, сэтгэлийг зовоодог нэг зүйл бол маргаашийнхаа талаар санаа зовох явдал юм.

Маргаашийн төлөө санаа зоволгүйгээр, өнөөдөртөө багтааж шийдэх асуудал бидэнд хангалттай их байдаг. Бурхан танд өнөөдрийн чинь нигүүлслийг өгөх боловч маргааш болохоос нааш маргаашийн чинь нигүүлслийг өгөхгүй.

Цаг нь болоогүй, магадгүй хэзээ ч болохгүй зүйлийн төлөө хүмүүс сэтгэлээ чилээх нь олонтаа. “Хэрэв тэгвэл”, “хэрэв ингэвэл” яана аа гээд л... Таны толгойд ийм бодол эргэлдэж эхэлбэл та маш болгоомжтой байх хэрэгтэй. Учир нь эндээс таны санаа зовнил эхэлж болзошгүй юм.

Зарим хүмүүс хэт санаа зовомтгой байдаг бөгөөд тэдний энэ зовнил яваандаа айдас болж хувирдаг. Харин бид итгэлээрээ Бурханаас хүлээн авах боломжтой. Түүнчлэн бид айдсаар дамжуулан диаволоос ч хүлээн авах боломжтой гэдгийг мартаж болохгүй.

Маргаашийн төлөө сэтгэлээ бүү түгшээ. Үүний тулд Бурхан бол итгэмжтэй гэдгийг мэдэхэд л хангалттай. *Маргааш хэрэгтэй зүйлийг Бурхан маргааш л өгнө.* Бидний хэрэгцээг хангахад Бурханы нигүүлсэл хангалттай билээ. Өнөөдрийн сайхныг мэдрэх нигүүлслийг маргаашийн төлөөх санаа зовнилоор бүү үгүй хий. Хэрэв бид өнөөдрөөрөө амьдарч сурвал Христ дотор гайхамшигтай зүйлийг гүйцэлдүүлж чадах болно.

Миний хувьд, би Библийн сургуульд дөнгөж багшилж эхэлж байх үедээ энэ зүйлд суралцсан юм. Тэр үед би чуулгандаа туслах пастороор үйлчилдэг байсан болохоор долоо хоногт нэг удаа чуулган дээрээ сургаал заадаг байв. Тэр үед надад Библийн сургуульд долоо хоногт гурван удаа хичээл заах боломж гарч ир-

сэн юм. Дөрвийн дөрвөн хүүхэдтэй би вээр, чуулгандаа бүтэн цагаар үйлчилдэг байсан хэдий ч энэ боломжийг алдахыг хүсээгүй юм. Учир нь би Бурханы Үгийг илүү ихээр заахыг үнэн сэтгэлээсээ хүсдэг байлаа.

Тийнхүү би тэр ажлыг хийхээр боллоо. Хичээлээ заахын тулд илүү их зүйл судлах, бэлтгэх хэрэгтэй болов. Библийг нарийвчлан судалж буй оюутнуудад заахын тулд Бурханы Үгийг илүү гүнзгийрүүлэн судлах шаардлага өөрийн эрхгүй урган гарч ирсэн юм. Ялангуяа эхний жил энэ тал дээр маш их цаг зарцуулах хэрэгтэй шаардлагатай болсон. Өдөр нь ажилтай учраас хичээлийн бэлтгэл, судалгааны ажлаа шөнө сууж хийдэг байлаа. Энэ бүхнийг яаж амжуулахаа үнэндээ мэдэхгүй байсан хэдий ч Бурхан надаас үүнийг хүсэж байна гэж итгэж байсан.

Тэгээд маш их залбирч, бас бодож эргэцүүлсний эцэст боломжгүй зүйлийг Бурханы дотор хийхийн тулд би нөхцөл байдлаасаа гарч, Түүний дотор орсон юм. Бурхан надад: “чи өнөөдрийнхөө ажлыг өнөөдөртөө л хий” гэсэн нэг л

зүйлийг хэлсээр байв. Хэрэв би маргаашийн талаар бодож эхлэх юм бол маш амархан зовлонд унах байлаа. Учир нь маргаашийн тухай бодох л юм бол тэр даруй боломжгүй зүйлс л надад харагдах байв. Харин тухайн өдрийнхөө ажлыг тухайн өдөрт нь л хий гэсэн Бурханы үг надад үнэхээр их тус болсон. Бурхан надад тухайн өдрийн нигүүлслийг тухайн өдөрт нь л өгсөн. Тэр маргаашийн нигүүлслийг урьд өдөр нь өгдөггүй. Тийнхүү ажилд орсон хоёр дахь жилээс эхлэн миний ажил маш хөнгөн болж эхэлсэн. Заах ёстой хичээлүүд бүгд бэлэн болсон учраас эхний жил шигээ шөнө дөлөөр сууж судалгаа хийх шаардлагагүй болсон юм.

Оюутнуудад Библи заахын хажуугаар ийм судалгааны ажил хийхийг Бурхан надаас хүссэн нь хоёр гол шалтгаантай байсан. Эхнийх нь, хэрэв бид амьдралыг нэг л өдрөөр хэмжин, өнөөдрөөрөө амьдарч сурвал Бурханы нигүүлслээр дамжуулан ямар их зүйлийг гүйцэлдүүлж болдгийг мэдрүүлэх; удаах нь, үүнийг бусдад байнга зааснаар улам илүү

дадал туршлагатай болгох явдал байсан. Дэйв бид хоёр байнга олон газраар явж сургаал заадаг. Үүнийхээ хажуугаар бид гэртээ “Бурханы Үгийн дагуу амьдрах нь” гэсэн сэдэвтэй уулзалтыг тогтмол хийдэг. Бурхан бол сайн бөгөөд Түүний арга замууд төгс билээ.

Хүмүүсийг зовоож шаналгадаг өөр нэг зүйл бол *харамсал* юм. Тэд өчигдрийнхөө хойноос харамсан шаналдаг. Хүн бүр алдаж онодог. Тийм ээ, “Бид бүгдээрээ алдаж онодог” гэж би хэллээ. Хэзээ ч буруу юм хийхгүй хүн гэж бодож байсан хүн тань хүртэл алдаа гаргадаг. Хүн бүр өөрийн ачааг үүрдэг гэж Библид хэлсэн байдаг (**Галат 6:5**). Бид бүгд адилхан хэлэхийг хүсээгүй үгээ хэлж, хийхийг хүсээгүй юмсаа хийж орхидог. Ам алдвал барьж болдоггүй гэдэг шиг нэгэнт хийсэн л бол хийсэн, эргүүлэх аргагүй.

Одоо яаж ч хичээгээд өөрчилж чадахгүй нэгэнт хийсэн алдааныхаа төлөө сэтгэлээ шаналгаж суухын оронд түүнийгээ Бурханд өргөөд, Түүнд найд. Таны мэддэг тэрхүү хүч чадал Түүнд бий. Тэр таны алдаа дутагдлыг цэвэрлэх болно.

Заримдаа би хэлэхийг хүсээгүй үгээ тэсгэлгүй хэлчихсэн байдаг. Тийм үедээ би үүнээс болж хэн нэгэн гомдоо болов уу, уурлаа болов уу гэж санаа зовж суухынхаа оронд тэр үгийг үнэн сэтгэлээсээ хэлээгүйг минь тэдэнд ойлгуулж өгөөч гэж Эзэнээс гуйдаг. Би Түүнийг тэдний зүрх сэтгэл дотор ажлаа хийнэ гэж итгэдэг. Үүний дүнд би хэлсэн үгнээсээ болж олон өдрийн турш шаналж, нөгөө хүмүүсээ харах тоолонд газар доогуур орчих шахах шаардлагагүй болдог.

Харамсах гэгч энэ урхинд биднийг оруулдаг зүйл олон байдаг. Дэйв бид хоёр зав муутай байдаг болохоор ихэнхдээ гадуур хооллодог. Заримдаа хоол муутай, эсвэл үйлчилгээ тааруухан газар тааралдана. Тийм газар хооллосныхоо дараа хэрэггүй тийшээ орлоо гэж нэг хэсэгтээ харамсана. Гэтэл Эзэн бидэнд тааруухан хоолны газар сонгосныхоо төлөө ингэж харамсах нь хүртэл бидний амар амгалан байдлыг эвдэж орхидог гэдгийг харуулсан.

Хэрэв та амар тайван амьдрахыг хүсэж байгаа бол хүч хүрэхгүй зүйлээ хийх

гэж оролдохоо боль гэж хэлснийг бүү март. Нэгэнт л та тухайн байгууллагаар үйлчлүүлээд, түүнийхээ төлөө мөнгө төлсөн бол амтгүй хоол идлээ гэж мянга харамсаад юуг ч өөрчилж чадахгүй.

Харин бид иймэрхүү нөхцөл байдлыг өөдрөгөөр харж, бидний сайн сайхны төлөө ажиллах боломжийг тэдэнд өгөх хэрэгтэй. Одоо бидэнд тиймэрхүү газар таарвал бид: “Хичнээн хүн энэ газар хоол идэхээр ирээд, сэтгэл дундуур гарах бол? Бид харин ч азтай хүмүүс биш гэж үү. Яагаад гэвэл, эндхийн хоол муу гэдгийг мэдээд авчихлаа. Тийм болохоор дахиж ийшээ ирж цаг зав, мөнгөө дэмий гарздахгүй боллоо” гэж хэлдэг.

“Хэрэв та өнгөрсөн дурсамжаараа амьдрах гэж хичээж байгаа бол таны амьдрал хүнд байх болно. Есүс Өөрийнхөө тухай өгүүлэхдээ ‘Би байсан’ гэж хэлээгүй шүү дээ. Түүнчлэн хэрэв та ирээдүйгээр амьдрах гэж хичээж байгаа бол таны амьдрал мөн л хүнд байх болно. Учир нь Есүс Өөрийгөө ‘Би байх болно’ гэж хэлээгүй. Харин та шинэ өдөр бүрийг шинээр угтан, тухайн өдрөөрөө амьдрах ав-

аас таны амьдрал үрж жимстэй байх болно. Учир нь Есүс Өөрийгөө ‘Би байдаг’ **(Иохан 8:58)** гэж хэлсэн” гэсэн үгс бүхий бичиг миний өрөөний ханан дээр байдаг юм. Ямар ч нөхцөл байдалд Есүс тантай хамт байж, бүх зүйлийг хяналтдаа байлгадаг Тиймээс өнөөдрийн чинь төлөө Тэр танд хангалттай нигүүлслийг өгнө гэдэгт итгэх хэрэгтэй.

ЗАЛБИРАЛ ТАНД АМАР ТАЙВНЫГ АВЧИРДАГ

Филиппой 4:6–7-д:

“Юунд ч бүү санаа зов. Харин аливаа зүйлд залбирлаараа болон гуйлтаараа талархалтайгаар хүсэлтээ Бурханд мэдүүл. Бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар тайван нь Христ Есүс дотор та нарын зүрх сэтгэл, санаа бодлыг хамгаална”.

Бүх оюун ухаанаас дээгүүрх амар тайвныг мэдэрнэ гэдэг үнэхээр агуу зүйл биш гэж үү! Сэтгэлээр унамаар, сандарч балмагдмаар, шаналж зовмоор нөхцөл байдал дунд үгээр илэрхийлэхийн аргагүй амар тайвныг мэдэрнэ гэдэг үнэхээр гайхамшигтай. Энэ дэлхий ийм л амар тайвнаар гачигдаж дутагдаж байдаг. Та ийм агуу амар тайвныг юугаар ч худалдаж авч чадахгүй. Энэ бол Есүсээс бидэнд ирдэг бэлэг юм. Түүнийг Аврагч Эзэнээ болгон хүлээн авч, улмаар Түү-

ний зарчмуудын дагуу үйлдэж сурах үед энэ бэлэг таных болдог.

Өөрийгөө Түүнд зориулж буйгаа тунхаглан залбир. Энэ залбирлын хүчээр дамжуулан таны нуруун дээрх ачаа дарамт Есүсийнх болдог. **1 Петр 5:7-д: “Тэр та нарын төлөө санаа тавьдаг учраас бүх зовнилоо Түүнд үүрүүл”** гэжээ. Библийн англи орчуулгын өөр нэг хувилбарт энэ ишлэлийг:

“Тэр та нарын төлөө санаа тавьдаг учраас бүх зовнилоо [сэтгэлийн түгшүүр, санаа зовнил, шаналал зэргээ бүгдийг нь] Түүнд үүрүүл” гэсэн байдаг.

Ямар агуу, ямар онцгой эрх вэ! Гэтэл олон христитгэгч өөрсдөдөө байгаа энэ агуу давуу эрхийг огт ашигладаггүй.

Та бүх санаа зовнилоо Есүст үүрүүлээд, амар тайван байж чаддаг уу? Үүрүүлэх гэдэг үг нь чулуудах, хаях гэсэн утгатай аж. Санаа зовнилоо аль болох түргэн үүрүүлэх тусам танд илүү сайн байх болно. Та үүнийг залбирлаар дамжуулан хийгээрэй. Таныг хайрлан, танд санаа тавьдаг Түүнд өөрийнхөө бүх асуудлыг даатга. Ямар нэг зүйлд санаа зовниж,

түүнээсээ болж сэтгэл чинь тайван бус болж байгааг Ариун Сүнс танд сануулсан даруй та залбирч, энэ бүхнээ Эзэнд даатгаарай.

Диавол таны сэтгэлийг зовоохыг хүсдэг. 1 Петр 5:9-р ишлэлд диаволыг бат итгэлээрээ эсэргүүц гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, диавол тань уруу довтолж эхэлмэгц шууд эсэргүүцэх хэрэгтэй гэж хэлж байна. Өөрийг тань олон өдөр дарамтлах боломжийг түүнд бүү тавьж өг. Түүнийг эсэргүүцэхгүй зөнд нь орхих тусам тэр таныг улам хүчтэй дарамталж, улмаар түүний дарамтаас чөлөөлөгдөхөд илүү хэцүү болно. Сэтгэл чинь тавгүйтэж байгаагаа мэдсэн даруйдаа биеэ барьж, санаа зовнилоо Бурханд үүрүүлж сурах хэрэгтэй. *Бодол сэтгэлгээгээ өөрчил.*

Аливаа зүйлд санаа “зовнихоо болиод”, “бүх зовнилоо Есүст үүрүүлэх” хэрэгтэй гэсэн энэ зарчмыг би анх сурч байх үедээ миний бодол сэтгэлгээ ямар буруу байсныг ойлгосон юм. Би бүх л өдөржингөө бүтэлгүй төсөөлөлд умбаж, түүндээ итгэн сэтгэлээр унаж, арга мухарддаг байв. Тэгээд: “Хүн яаж юу ч бодохгүй

байж чадах юм бэ?” гэж өөрийгөө зөвтгөн Эзэнээс асуудаг байлаа. Санаа зовохгүй байхын тулд асуудлынхаа талаар бодох хэрэггүй юм байна гэдгийг би ойлгосон. Хэрэв шийдвэр гаргахын тулд тухайн асуудлын талаар бодож эрэгцүүлэх шаардлагатай бол сөрөг биш, эерэг талаас нь бодож үзэх хэрэгтэй. Та өөртөө тулгараад байгаа асуудлыг сөрөг талаас нь бус, харин бодитоор авч үзэж болно шүү дээ.

“Эзэн минь, би энэ асуудлын талаар бодохгүй байж яаж чадах юм бэ?” хэмээн асуух үед Есүс надад “Жойс оо, энэ тун амархан. Зүгээр л өөр ямар нэг зүйлийн талаар бод” гэж хариулсныг би маш тод санаж байна. Хэрэв танд асуудал болоогүй өөр ямар нэг зүйлийн талаар бодвол та асуудлынхаа талаар бодохгүй байж чадна.

Филиппой 4:6-д юунд ч бүү санаа зов, харин түүний оронд залбир гэж хэлдэг. Харин **7-р** ишлэлд, хэрэв та тэгж чадвал бүх оюун ухаанаас дээгүүрх амар тайвныг мэдэрч чадна гэж амлажээ. **8-р** ишлэлд: *“Эцэст нь, ах дүү нар аа, юу нь*

үнэн, юу нь хүндэтгэлтэй, юу нь зөв, юу нь цэвэр ариун, юу нь сайхан, юу нь сайшаалтай байна, хэрэв аливаа сайн үйл байгаа бол, хэрэв магтууштай ямар нэгэн юм байгаа бол тэдгээр юмсыг бодож санацгаа” гэсэн байдаг.

Ингээд би амар тайвнаар дүүрэн ерөөгдсөн амьдралаар амьдрахын тулд эдгээр зарчмыг амьдралдаа хэрэгжүүлэх Ариун Сүнсний хүч болох нигүүлслийг Бурхан танд өгөхийн төлөө залбирч байна. Түүнчлэн Бурхан Эцэг таныг Өөрийн алдрын төлөө ашиглахын төлөө би залбирч байна.

ИТГЭЛИЙН ЗАЛБИРАЛ

Бурхан танд хайртай бөгөөд хувьчилсан харилцаа тогтоохыг хүсэж байна. Хэрэв та Есүс Христийг таны аврагч гэдгийг өмнө нь хүлээн зөвшөөрөөгүй бол танд боломж байна. Түүнд зүрх сэтгэлээ нээгээд энэ залбирлыг хэлээрэй:

“Ариун Эцэг Бурхан минь, би Таны эсрэг гэмтэй гэдгээ мэднэ намайг уучлаач, намайг цэвэрлээч. Би Таны Хүү Есүс Христэд итгэхээ амлаж байна, итгэж байна. Тэр загалмайд цовдлогдохдоо миний гэмийг Өөртөө үүрсэн. Тэр миний төлөө нас барсанд би итгэж байна. Тэр үхлээс дахин амилсанд би итгэж байна. Би одоо өөрийнхөө амьдралыг Танд өргөж байна. Намайг уучилж, мөнхийн амьдрал өгсөнд баярлалаа. Эцэг Бурхан минь, Тантай хамт амьдрахад надад туслаач Есүсийн нэрээр амен”.

Хэрэв та зүрх сэтгэлээсээ гуйсан бол Тэртаныг хүлээн авч сүнсний боолчлолоос таныг чөлөөлж, цэвэрлэх болно. Библи уншиж Түүнд цаг гаргавал асуултынхаа хариултыг авах ба шинэ амьдралдаа Түүнтэй хамт аялаарай.

Иохан 3:16

Ефес 1:4

1 Иохан 1:9

1 Иохан 5:1

1 Коринт 15:3-4

Ефес 2:8-9

1 Иохан 4:14-15

1 Иохан 5:12-13

Түүнээс Библи болон зөвт сүмийг гуйн асууж Христтэй хамт нөхөрлөн өсөж урамыг аваарай. Бурхан үргэлж тантай хамт, Тэр таны амьдралыг удирдах бөгөөд Тэр таны амьдралыг элбэг хангалуун байлгах болно.

Иохан 8:31–32-р ишлэлд:

“...Хэрэв та нар Миний үгэн дотор байвал үнэхээр Миний дагалдагчид байна. Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө...” гэсэн байдаг.

Би та нарыг Бурханы Үгнээс зуурч, түүнийг зүрх сэтгэлдээ гүн суулган, Түүний Үгийг унших бүрдээ Есүс Христийн дүрд алдраас алдарч өөрчлөгдөөсэй хэмээн уриалан ятгаж байна.

*Та нартаа хайртай,
Жойс*

ЗОХИОГЧИЙН ТУХАЙД

Жойс бол дэлхийд Библийг заагч удирдагч багш нарын нэг нь билээ. “Нью-Йорк Таймсын” хэвлэл нь хамгийн ихээр зарагдсан зохиолч болох түүний номнууд нь сая сая гаруй хүмүүс Есүс Христээр дамжуулан амьдралдаа итгэл найдвар болон сэргэлтийг олоход тусалсан юм.

Жойс Майерийн үйлчлэл байгууллагаар дамжуулан, тэр төрөл бүрийн сэдвээр ялангуяа хүний оюун ухаан, хэл яриа, зан төлөв болон хандлагуудад төвлөрсөн хичээлүүдийг заадаг. Түүний энгийн харилцан ярианы хэлбэр нь түүнийг нээлттэйгээр хуваалцах болон тэр тусмаа өөрийнх нь туулж өнгөрүүлсэн амьдралын туршлагтай нь хослуулдаг бөгөөд ингэснээр энэ нь бусад хүмүүс түүнээс суралцсан зүйлээ амьдрал дээрээ хэрэгжүүлэхэд тус дөхөм болдог.

Жойс ойролцоогоор 100 гаруй ном бичсэн бөгөөд тэдгээр нь 100 гаруй орны хэлээр орчуулагдсан юм. Тэрээр жил бүр ойролцоогоор орон нутгийн болон олон улсын 12 чуулга уулзалт зохион байгуулж, бусад хүмүүсийг өдөр тутмынхаа амьдрал-

даа баяр хөөртэй амьдрахыг зааж байна. Өнгөрсөн 30 жилийн туршид явуулсан түүний жил бүр зохион байгуулладаг эмэгтэйчүүдийн чуулга уулзалтууд нь дэлхийн өнцөг булан бүрээс 200 000 илүү эмэгтэйчүүдийг оролцуулсан юм.

Зовж шаналсан хүмүүст туслахыг хүссэн Жойсын хүсэл тэмүүлэл нь **“Жойс Майерийн үйлчлэл”** шиг тусламжийн гарын гол хараа нь болсон **“Найдварын Гар”** байгууллагын үндэс суурь нь байсан бөгөөд тэрээр өнцөг булан бүрт байгаа дэлхийн хүмүүст, түүнчлэн түүний өөрийнх нь төрсөн хот болох Сэинт Луйст хүртэл тусламжийн үйлчлэлийг нь дэмждэг юм.

“Жойс Майерийн үйлчлэл”-ийн
материалуудыг өөр олон хэл дээр
tv.joycemeyer.org
сайтаас авч/үзэх боломжтой.

ЖОЙС МАЙЕРИЙН ҮЙЛЧЛЭЛ МОНГОЛД

Жойс Майерийн монгол хэлээр
орчуулагдсан номууд:

“Амьдралын шинэ зам”

“Итгэл найдвараар ирээдүйгээ хар!”

“Мэдрэмжээ залж амьдрах ухаан”

“Оюун ухаан тулалдааны талбар”

“Хайртай гэдгийг минь тэдэнд хэлээрэй”

“Жойс Майерийн үйлчлэл”-ийн материалуудыг
монгол хэлээр орж үзэх ба татаж авах боломжтой:

joycemeyer.mn

youtube.com/c/JoyceMeyerMinistriesMongolia

facebook.com/JoyceMeyerMinistriesMongolian

Дараах хаяг, утасны дугаараар холбогдоно уу:
16092 ш/х 504, Улаанбаатар-23, Монгол улс.

E-mail: **contactus@joycemeyer.mn**

Утас: +976 99700060

Оффис хаяг: Энхтайваны өргөн чөлөө, 25-р эмийн
сангийн буудал, Кёкүшю цамхагийн 404 тоот

Өөрийнхөө Бүх Асуудлыг Бурхан Өг...

Тэгвэл Тэр Танд Амар Тайван Хийгээд Баяр Баясгаланг Өгнө!



Та боломжгүй зүйлийг болгох гэж хичээж байна уу? Эргэн тойрондоо байгаа хүмүүсийг өөрчлөхийг хичээн улайран зүтгэж байна уу? Та сүнсний хувьд байх ёстой газраа байхгүй байгаадаа сэтгэл гундуу байна уу? Таны амар тайван өдрөөс өдөрт алдагдсаар байна уу? Хэрэв таны дотор амар тайван байхгүй

бол та амьдралын сайхныг мэдэрч чадахгүй. Гэвч асуудал бэрхшээлийн дунд ч тайван амгалан байж, өдөр тутмынхаа амьдралыг хэрхэн удирдаж болдгийг Жойс Майер энэ номдоо өгүүлж байна. Тэрээр танд дараах зүйлсийг зааж байна:

- ◆ Бурханыг болон Түүний товлосон төгс цагийг хүлээх;
- ◆ таныг сэтгэлээр унагахын төлөө бүхнийг хийдэг, “амар тайвны хулгайчаас” илүү ухаалаг байх;
- ◆ таны хандлагыг итгэл найдвараар дүүрэн, амар амгалан байлгах хүчийг олж авах;
- ◆ өнөөдрийнхөө нигүүлсэлд анхаарлаа хандуулан, маргаашийн төлөө санаа зовохгүй байх.

Бурханы амар тайван бол бүх оюун ухаанаас дээгүүр билээ. Энэ бол Түүнээс бидэнд өгөгдсөн бэлэг юм. Та энэ бэлгийг хүлээн авахад бэлэн байна уу?